



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/85.

Алтанбулаг

**Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, дахь заалтууд 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйл, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5, 14.7, 14.8, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3, 21.6, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 22.6 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 01 тоот албан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын 2018 оны “Үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээ тогтоох тухай” 41 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/197 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Нийгмийн эрүүл мэнд, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрүүлжүүлэх мал амьтны өвчлөлийн байдлыг бүртгэх мэдээллэх, ажил үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах хяналт тавих зорилгоор сумын хэмжээнд “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г төлөвлөгөөт хугацаанд зохион байгуулсугай.

2. “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч :

Ү. Янжиндулам

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд :

М. Цэгмид

(Тархвар зүйч)

Э. Зориг

(1 дүгээр багийн Засаг дарга)

Н. Мөнхзул

(2 дугаар багийн Засаг дарга)

Г. Мөнхболд

(3 дугаар багийн Засаг дарга)

Л. Гантөмөр

(Бумбат-Өлгий ББН мал эмнэлгийн малын эмч)

Р. Булгаа

(Бөхлөө-Хангай ХХК мал эмнэлгийн малын эмч)

3. “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажил арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.1.Лабораторийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, үзлэг тандалт, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтанд сумын хэмжээний мал амьтанг бүрэн хамруулах.

3.2.Эрсдэлтэй бүс нутгаас тээвэрлэгдэн ирж буй мал амьтан болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавих, хүнсний зориулалтаар бэлтгэн тээвэрлэж байгаа мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг холбогдох журам зааврын дагуу олгож мал амьтны шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавьж ажиллах.

3.3 Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээний явц үр , ажлын гүйцэтгэлийн тайланг сумын Засаг даргад танилцуулж аймгийн Мал эмнэлгийн газарт тайлагнах.

3.4 Урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг мал эмнэлгийн нэгдсэн цахим системд бүрэн оруулах, хяналт тавьж ажиллах.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү. Янжиндулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ

